

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/67/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор: О.Барчидгүнсэн
Утас: 70512127 Цахим хаяг: barchidgunseno@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
4. 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
5. 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
6. 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
7. 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
8. 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
9. 3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
10. 4. Аудитын илрүүлэлт	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж	17
11. 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТСУХ	Биеийн тамир спортын улсын хороо

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 59

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
А.ГАНХҮҮ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төсөвт төвлөрүүлэх үлдэгдлээр материал нөөцөлсөн, засварын ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, мөн гэрээг хэсэгчлэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан, гадна гэрэлтүүлгийг он дамжуулан гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, хөрөнгө шилжүүлэн, төсвийн гүйцэтгэлийг алдаатай илэрхийлсэн, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2. 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3. 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>144,547,357.17</u>	<u>145,283,236.45</u>
33	АВЛАГА	14,440,708.73	14,881,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,040,708.73	881,000.00
335	Бусад авлага	12,400,000.00	14,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	12,400,000.00	14,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	501,583.00	18,691.01
3471	Урьдчилгаа тооцоо	501,583.00	18,691.01
34713	Цалингийн урьдчилгаа	501,583.00	18,691.01
35	БАРАА МАТЕРИАЛ	129,605,065.44	130,383,545.44
351	Түүхий эд материал	205,500.00	00.00
35130	Эм боох материал	205,500.00	00.00
354	Хангамжийн материал	129,399,565.44	130,383,545.44
35410	Бичиг хэргийн материал	196,000.00	84,000.00
35420	Аж ахуйн материал	65,745,468.44	67,494,468.44
35440	Түлш, шатах тослох материал	6,582,740.00	1,159,544.00
35450	Барилгын засварын материал	6,224,000.00	6,134,000.00
35470	Бусад хангамжийн материал	50,651,357.00	55,511,533.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,838,531,261.15</u>	<u>7,525,686,549.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,838,531,261.15	7,525,686,549.43
392	Биет хөрөнгө	3,621,091,261.15	7,071,664,549.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,720,326,370.00	5,341,877,828.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-231,414,965.32	-287,246,343.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,600,000.00	63,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-72,433,333.55	-38,033,333.63
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	278,579,174.00	296,750,234.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,758,852.93	-103,113,498.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,306,834.00	148,306,834.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,100,023.05	-68,804,764.09
39214	Бусад үндсэн хөрөнгө	250,982,850.00	250,982,850.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-91,496,782.00	-135,155,246.56
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,602,499,990.00	1,602,499,990.00
393	Биет бус хөрөнгө	217,440,000.00	454,022,000.00
39301	Програм хангамж	5,950,000.00	5,950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,950,000.00	-5,950,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	217,440,000.00	454,022,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,983,078,618.32</u>	<u>7,670,969,785.88</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>820,850.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	820,850.00
413	Өглөг	00.00	820,850.00
4136	Бусад өглөг	00.00	820,850.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	348,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	472,850.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,983,078,618.32</u>	<u>7,670,148,935.88</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,983,078,618.32	7,670,148,935.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	2,149,822,608.70	2,149,822,608.70

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	2,149,822,608.70	2,149,822,608.70
512	Хуримтлагдсан үр дүн	1,580,500,620.92	5,267,570,938.48
51210	Өмнөх үеийн үр дүн	1,580,500,620.92	1,580,500,620.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	3,687,070,317.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	252,755,388.70	252,755,388.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,983,078,618.32</u>	<u>7,670,969,785.88</u>

4. 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,528,591,340.00	5,149,186,018.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,589,854,040.00	4,204,877,118.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,589,854,040.00	4,204,877,118.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,589,854,040.00	4,204,877,118.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	6,707,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	9,088,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,589,854,040.00	4,189,081,518.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	938,737,300.00	944,308,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	460,373,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	460,373,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,950,700.00	20,380,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,120,000.00	10,174,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,830,700.00	5,206,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	898,786,600.00	463,555,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	898,786,600.00	463,555,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,074,646,390.76	1,271,027,700.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,074,646,390.76	1,271,027,700.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,045,323,911.44	1,249,241,074.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	371,504,597.12	362,488,941.48
210101	Үндсэн цалин	371,504,597.12	362,488,941.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,438,073.62	47,422,069.69
210201	Тэтгэврийн даатгал	31,577,891.44	33,051,135.32
210202	Тэтгэмжийн даатгал	3,715,045.26	3,679,489.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,972,036.11	2,930,151.28
210204	Ажилгүйдлийн даатгал	743,008.53	705,572.33
210205	Эрүүл мэндийн даатгал	7,430,092.28	7,055,721.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	351,545,084.00	348,205,647.00
210301	Гэрэл, цахилгаан	25,817,778.00	10,317,023.00
210302	Түлш, халаалт	309,117,270.00	309,117,900.00
210303	Цэвэр, бохир ус	16,610,036.00	28,770,724.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,118,766.67	13,647,824.00
210401	Бичиг хэрэг	2,662,500.00	902,735.00
210402	Тээвэр, шатахуун	13,486,234.67	7,590,696.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,480,350.00	2,629,438.00

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	348,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	491,500.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,649,782.00	2,074,955.00
2105	Нормативт зардал	3,502,000.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,702,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,196,561.94	96,303,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	66,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	694,500.00	00.00
210604	Урсгал засвар	46,202,061.94	96,237,150.00
2107	Томилолт, зочны зардал	1,956,000.00	919,000.00
210702	Дотоод албан томилолт	1,956,000.00	919,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,827,925.00	10,833,539.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,448,100.00	10,833,539.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	166,400.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	76,175.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,254,750.00	00.00
210807	Газрын төлбөр	200,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	832,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,234,903.09	369,420,903.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,838,500.00	43,071,674.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,396,403.09	326,349,229.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,322,479.32	21,786,625.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,025,819.00	10,528,381.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,025,819.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	10,528,381.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,296,660.32	11,258,244.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,296,660.32	11,258,244.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,453,944,949.24</u>	<u>3,878,158,317.56</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	112,500.00	191,088,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	112,500.00	191,088,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-112,500.00	-191,088,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,453,832,449.24</u>	<u>3,687,070,317.56</u>

5. 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,149,822,608.70	252,755,388.70	126,668,171.68	00.00	2,529,246,169.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,149,822,608.70	252,755,388.70	126,668,171.68	00.00	2,529,246,169.08
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-19,105,980.14	00.00	-19,105,980.14
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,149,822,608.70	252,755,388.70	1,580,500,620.92	00.00	3,983,078,618.32
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,149,822,608.70	252,755,388.70	1,580,500,620.92	00.00	3,983,078,618.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,149,822,608.70	252,755,388.70	1,580,500,620.92	00.00	3,983,078,618.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,687,070,317.56	00.00	3,687,070,317.56
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,149,822,608.70	252,755,388.70	5,267,570,938.48	00.00	7,670,148,935.88

6. 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	984,331,368.00	965,153,284.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	16,580,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	16,580,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	15,795,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	6,707,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	9,088,600.00
120009	Бусад орлого	00.00	785,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	984,331,368.00	948,572,684.73
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	45,594,068.00	460,373,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	460,373,500.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	45,594,068.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,950,700.00	22,420,708.73
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,120,000.00	10,174,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,830,700.00	7,246,708.73
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	898,786,600.00	463,555,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	898,786,600.00	463,555,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	2,223,076.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	2,223,076.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	971,045,878.00	962,042,284.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	971,045,878.00	962,042,284.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	939,154,891.95	937,151,583.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	375,965,848.12	362,006,049.49

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	375,965,848.12	362,006,049.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,438,076.83	47,422,069.69
210201	Тэтгэврийн даатгал	31,577,894.29	33,051,135.32
210202	Тэтгэмжийн даатгал	3,715,050.68	3,679,489.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,972,034.78	2,930,151.28
210204	Ажилгүйдлийн даатгал	743,006.80	705,572.33
210205	Эрүүл мэндийн даатгал	7,430,090.28	7,055,721.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	350,995,174.00	358,605,647.00
210301	Гэрэл, цахилгаан	25,817,778.00	20,717,023.00
210302	Түлш, халаалт	308,567,360.00	309,117,900.00
210303	Цэвэр, бохир ус	16,610,036.00	28,770,724.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,533,672.00	8,155,364.00
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	708,765.00
210402	Тээвэр, шатахуун	17,708,660.00	2,167,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,575,450.00	2,629,438.00
210404	Ном, хэвлэл	348,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,621,162.00	2,199,661.00
2105	Нормативт зардал	3,200,000.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,210,458.00	104,498,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,880,000.00	4,339,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	900,000.00	204,000.00
210604	Урсгал засвар	60,430,458.00	99,955,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,956,000.00	919,000.00
210702	Дотоод албан томилолт	1,956,000.00	919,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,011,743.00	11,691,883.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,487,018.00	11,691,883.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	166,400.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	76,175.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,399,650.00	00.00
210807	Газрын төлбөр	200,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	832,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,843,920.00	43,853,270.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,843,920.00	43,853,270.00

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,890,986.05	24,890,701.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,025,917.00	12,751,457.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,223,076.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,025,917.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	10,528,381.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,296,660.32	12,139,244.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,296,660.32	12,139,244.55
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,568,408.73	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,568,408.73	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,285,490.00	3,111,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,285,490.00	3,111,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,285,490.00	3,111,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,285,490.00	3,111,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,285,490.00	3,111,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,285,490.00	-3,111,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

7. 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,011,564,300.00	930,690,459.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,011,564,300.00	930,690,459.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,003,497,700.00	920,400,783.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	369,720,000.00	362,006,049.49
210101	Үндсэн цалин	369,720,000.00	362,006,049.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,912,200.00	47,422,069.69
210201	Тэтгэврийн даатгал	35,123,400.00	33,051,135.32
210202	Тэтгэмжийн даатгал	3,697,200.00	3,679,489.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,957,600.00	2,930,151.28
210204	Ажилгүйдлийн даатгал	739,600.00	705,572.33
210205	Эрүүл мэндийн даатгал	7,394,400.00	7,055,721.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	407,117,900.00	358,605,647.00
210301	Гэрэл, цахилгаан	58,000,000.00	20,717,023.00
210302	Түлш, халаалт	309,117,900.00	309,117,900.00
210303	Цэвэр, бохир ус	40,000,000.00	28,770,724.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,077,600.00	8,077,564.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	708,765.00
210402	Тээвэр, шатахуун	2,167,500.00	2,167,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,630,100.00	2,629,438.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,073,400.00	450,000.00

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	706,600.00	2,121,861.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,204,200.00	100,159,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	204,200.00	204,000.00
210604	Урсгал засвар	100,000,000.00	99,955,300.00
2107	Томилолт, зочны зардал	919,000.00	919,000.00
210702	Дотоод албан томилолт	919,000.00	919,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,806,300.00	10,731,883.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,806,300.00	10,731,883.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56740500.00	32479270.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,740,500.00	32,479,270.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8066600.00	10289676.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,066,600.00	10,289,676.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,223,076.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,066,600.00	8,066,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,011,564,300.00	930,690,459.18
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	460,373,500.00	450,110,837.18
131001	Улсын төсвөөс санхүүжих	460,373,500.00	450,110,837.18
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	511,190,800.00	462,560,946.00
132001	Орон нутгийн төсвөөс	511,190,800.00	462,560,946.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	2,223,076.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	2,223,076.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	40,000,000.00	15,795,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,000,000.00	6,707,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	9,088,600.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44.00	42.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	23.00
620003	Үйлчлэх ажилтан	18.00	18.00

8. 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,323,581.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,323,581.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,861,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	77,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	77,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,450,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	960,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	960,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11374000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,374,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2461781.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,461,781.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,461,781.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22323581.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,323,581.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,174,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,149,581.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

9. 3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, тээвэр шатахуун, үндсэн хөрөнгө, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газар нь “Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг сайжруулж, нийтийн биеийн тамирт иргэдийн хамрах хүрээг өргөжүүлэх, их спортыг хөгжүүлж түүний залгамж халааг бэлтгэх, олимпизмыг сурталчлан түгээн дэлгэрүүлэх,бие бялдрын соёл боловсрол олгох, өндөр ур чадвартай тамирчин бэлтгэхэд оршино.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 1,271.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 12.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,687.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	14.4	14.8	0.4
Бараа материал	129.6	130.3	0.7
Үндсэн хөрөнгө	3,838.5	7,525.6	3,687.1
Нийт хөрөнгө	3,983.0	7,670.9	3,687.9
Өр төлбөр	0.00	0.8	0.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,983.0	7,670.9	3,687.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,983.0	7,670.9	3,687.9

Бараа материалын дансны үлдэгдэл 130.3 сая төгрөг болж 0.7 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал 5.5 сая, аж ахуйн материал 1.8 сая, нийт 7.3 сая төгрөгөөр үлдэгдэл өссөн, түлш шатах тослох материал 5.4 сая, бичиг хэргийн материал 0.6 сая, нийт 6.0 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,690.9 сая төгрөг болж 3,687.9 сая төгрөгөөр өссөн нь усан бассейн барилга 3,758.8 сая, БТСУХ–ноос машин тоног төхөөрөмж 15.1 сая, наадмын талбайн газар 427.6 сая, нийт 4201.5 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн бөгөөд төсвийн хөрөнгөөр 3.1 сая төгрөг, нийт 4204.6 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, Аймгийн ИТХ-ын 2021 оны 53,37 дугаар тогтоолуудаар наадмын талбайг газрын хамт 328.3 сая, тээврийн хэрэгсэл 45.0 сая, нийт 373.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасагдаж, 326.6 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 14.8 сая төгрөг болж өссөн нь аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж гадна гэрэлтүүлэг хийлгэх ажил Ковид -19 цар тахлаас шалтгаалж хойшилсноор авлага үүсжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,670.9 сая төгрөг болж 3,687.9 сая төгрөгөөр өссөн байна.

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,620.6 сая төгрөгөөр өссөн нь улсын, орон нутгийн төсвөөс санхүүжилт 25.1 сая, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлого 15.7 сая төгрөгөөр нэмэгдсэн, мөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 2,599.2 сая, төгрөгөөр нэмэгдсэн, нэмэлт санхүүжилтийн орлого 19.5 сая төгрөгөөр буурсан тус нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатын төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 196.3 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хангамж, бараа материалын зардал, гэрэл цахилгааны зардал буурсан, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,623.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,623.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,011.5 сая төгрөгийн төсөв баталснаас 460.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 511.2 сая төгрөгийг орон төсвөөс санхүүжүүлэхээр, 34.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 6.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос тус тус төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 450.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 462.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 6.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 9.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос зарцуулж, нийт 928.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 12.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 928.4 сая төгрөг буюу 91.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 5.0 сая, дээд шатны төсөв захирагчаас 10.2 сая төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7.2 сая, нийт 22.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1.0 сая, багаж техник хэрэгсэл 7.5 сая, бараа үйлчилгээний бусад 11.4 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 2.4 сая, нийт 22.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарчээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайланд Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, орон нутгийн санхүүжилтээр урсгал засварын зардал 99.0 сая төгрөг баталж, барилгын дээвэр, өрөөнүүдийн засварын ажлыг хийлгэсэн боловч тендер зарлаагүй, бараа материалыг өөрсдөө татан авалт хийж, гүйцэтгэх ажлыг өөрсдийн ажилчид, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн боловч хүлээж авсан баримт материал байхгүй, гадна гэрэлтүүлэг хийлгэхээр аж ахуй нэгжээр хийлгэхээр мөнгө шилжүүлж, дараа оны 5 сард ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцорч 13 мэдээлэл, 5 мэдээллийг мэдээлэлгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурыг зарим зүйл нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,768.4 сая төгрөгийн зөрчилд 9.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 3,758.7 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлж, зарим зөвлөмж, албан шаардлага биелүүлээгүй байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	9.6	3	9.6	-	-	-
Албан шаардлага	3	3,758.7	1	3,758.7	2	-	80
Зөвлөмж	1	-	-	-	1	-	100
Нийт дүн							

Өмнөх оны хэрэгжүүлээгүй зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх талаар танилцуулаа.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

10. 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 101.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 101.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3 асуудалд зөвлөмж өгч, 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулаа

4.2 АЛБАН ШААРДЛАГА

4.2.1 Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг бодитой, үнэн зөв тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1¹, 72.4.2², 72.4.4³, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6⁴ дахь заалттай нийцэхгүй байна

4.2.2 Спорт заалны дээврийн засварыг 24.6 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, бараа материалыг худалдан авч, зөвхөн хучих ажлыг “Өсөх Таун Констракшн” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн, мөн 53.7 сая төгрөгийн дотор засварын ажлыг сонгон шалгаруулалт зарлаагүй, хэсэгчлэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан нийт 78.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа хуулийн дагуу хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 /харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;/, 8.5 /Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно/ 33 дугаар зүйлийн 33.1 /Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно/, 33.2.1.үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх/, 33.2.2.техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох/ заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол нийцэхгүй байна.

4.2.3 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор Ковид-19 цар тахлын нөхцөлд төсвийг үр ашигтай зарцуулж, хэмнэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг баталсан. Уг тогтоолыг баримтлалгүй үндсэн хөрөнгө, нормын хувцас худалдан авахад нийт 1.4 сая төгрөгийг зарцуулжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн

¹ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

² тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

³ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

⁴ эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

4.2.4 Гадна гэрэлтүүлгийг он дамжуулан гүйцэтгүүлэх 14.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, шилжүүлсэн, спортын заалны шал, ханыг будахаар 7.7 сая төгрөгөөр будаг худалдан авсан боловч ковид цар тахлаас шалтгаалж будаг хийгдээгүй, нийт 21.7 сая төгрөгийн төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

4.2.5 Сахилгын шийтгэл тооцуулах тухай

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төсөвт төвлөрүүлэх үлдэгдлээр материал нөөцөлсөн, засварын ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, мөн гэрээг хэсэгчлэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан, гадна гэрэлтүүлгийг он дамжуулан гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, хөрөнгө шилжүүлэн, төсвийн гүйцэтгэлийг алдаатай илэрхийлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 /харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар/, 8.5 /Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно/ 33 дугаар зүйлийн 33.1 /Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно/, 33.2.1 /үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх/, 33.2.2 /техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох/ заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг зөрчсөн байна

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.3.1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

4.3.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 92 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

4.3.1. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

4.3.2. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал

4.3.2. Илрүүлэлт:

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулаагүй нь Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын 1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуур суурилуулах ажлыг 2020 оны 3-р улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай” заалттай нийцэхгүй байна.

4.3.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

11. 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн Биеийн тамир спортын газрын	6	101.4	-	-	-	-	3	101.4	3	-